



ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛИЙН
ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА



Хичээлийн хөтөлбөрийн гарааны үнэлгээний дүгнэлт

2022.11.23

Энэрэл дээд сургуулийн Чанарын баталгаажилт, хяналт үнэлгээний албаны төлөвлөгөөт хяналт үнэлгээний хүрээнд зарим хичээлийн хөтөлбөрт гарааны үнэлгээ хийлээ. Үнэлгээг тусгайлан боловсруулсан хяналтын хуудас болон SWOT үнэлгээний аргачлал ашиглан хийлээ.

1. Хичээлийн хөтөлбөрийн давуу тал (Strength)

Хичээлийн хөтөлбөрийн давуу талын хувьд бүх хичээлийн хөтөлбөрүүд нь БШУЯ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын 2.3 зүйлийн дагуу бичигдсэн байна. А/174 дүгээр тушаалын 2.3-т дараахь зүйл, заалтууд байдаг.

2.3.1 Хичээлийн нэр, индекс, зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр (оюутан эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамж), энэхүү хичээлийг судлахын өмнө судалсан байвал зохих хичээлийн нэр, индекс

- 2.3.2 Хичээлийн үндсэн агуулга, хичээллэх өдөр бүрээр төлөвлөсөн судлах зүйлийн тойм, холбогдох эх сурвалж, гүйцэтгэх даалгавар
- 2.3.3 Оюутны гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх арга хэлбэр
- 2.3.4 Хичээлийг заах багшийн нэр, харилцах хаяг

Эдгээр зүйл заалтууд үнэлгээ хийгдсэн хөтөлбөрүүдэд бүрэн бичигдсэн нь хөтөлбөрийн давуу тал болж байна.

2. Хичээлийн хөтөлбөрийн сул тал (Weakness)

БШУЯ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” нь үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах зарчимд суурилсан байдаг. Үр дүнд суурилсан зарчмаар хичээлийн хөтөлбөр боловсруулахад хамгийн гол нь суралцахуйн үр дүнг маш сайн тодорхойлж түүнтэй уялдуулан хөтөлбөрөө боловсруулах хэрэгтэй гэж үздэг.

Иймд хичээл ба суралцахуйн үр дүнгийн уялдааг харуулсан хяналтын хуудас боловсруулсан. Уг хяналтын хуудсыг БШУЯ-ны сайдын 2014 оны А/174 тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага,” Азийн хөгжлийн банкны “L2766/MON: Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд боловсруулсан CDIO стандарт, арга зүй “Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж,” “Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүд тодорхойлох арга зүйн зөвлөмж,”-ийг ашиглан боловсруулсан.

Хичээлийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу 4 бүлгийн 6 асуулт, хичээл ба суралцахуйн үр дүнгийн хамаарлын 7 бүлгийн 11 асуулт бүхий нийт 100 оноо бүхий хяналтын хуудсаар 6 хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийж үзэхэд үнэлгээний дундаж **36.2** оноо байгаагаас үзэхэд, дараахь 4 дүгнэлтэд хүрлээ.

- 1) Үнэлгээнд орсон хичээлийн хөтөлбөрүүдийн боловсруулалт нь хичээл ба суралцахуйн үр дүнгийн уялдаа холбоо, хамаарлыг тооцдоггүй харуулж байна.
- 2) Үүнээс гадна, үнэлгээ хийгдсэн хичээлийн хөтөлбөрүүдийн сургалтын арга зүйн хувьд адил төстэй байсан. Энэ хичээл тус бүрээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага өөр байгаа хэдий ч сургалтын арга зүй нь ижил төстэй байгаа нь цаашид анхаарах зүйлийн нэг болж байна.
- 3) Мөн сургалтын үнэлгээний аргачлал бүгд ижил, ихэвчлэн мэдлэг үнэлэх арга хэрэгслүүд байсан.
- 4) Эцэст нь хэлэхэд, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сэдэв тус бүрээр нарийвчлан тодорхойлоогүй, зарим хөтөлбөрт маш товч дурьдагдах төдий өнгөрсөн байна.

3. Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах боломж (Opportunities)

Үр дүнд суурилсан зарчмаар боловсруулсан 100 онооны хяналтын хуудсаар үнэлгээ хийж үзэхэд **дунджаар 36.2** оноотой үнэлэгдсэн нь цаашид хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт хийхдээ дутагдалтай талуудыг засаж сайжруулснаар уг оноог ахиулах боломжтой болно үзлээ. Дараахь 4 үндсэн зарчмаар сайжруулалт хийнэ.

- 1) Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт хийхдээ уялдаа хамаарлуудыг сайтар тооцох. Үүнд:
 - Суралцахуйн үр дүнг суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний хөгжилд шаардлагатай мэргэжилтний цогц чадамж, мэдлэг, ерөнхий ур чадвар, хандлага, суралцагчдын хэрэгцээ шаардлагатай уялдуулан тооцох
 - Сургалтын хөтөлбөрийн үр дүн болон хичээлийн хөтөлбөрийн үр дүнгийн матриц боловсруулах
 - Хичээлээр эзэмших чадамж, мэдлэг, ур чадвар, хандлага ба хичээлийн агуулгын хамаарлын матриц боловсруулах
 - Хичээлийн сэдэв хоорондын агуулга болон суралцахуйн үр дүнгийн уялдаа холбоо хамаарлын матриц боловсруулах
 - Сургалтын хөтөлбөрийн үр дүн болон хичээлийн хөтөлбөрийн үр дүн, үнэлгээний арга зүйн матриц боловсруулах юм.

Үүний үр дүнд, хичээлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлага, цогц чадамж талаас нь илүү цогцоор ойлгож боловсруулах, цаашлаад суралцахуйн үр дүн (мэдлэг, ур чадвар, хандлага) нь сургалтын арга зүй, сургалтын үнэлгээтэй уялдах, эцсийн дүнд тухайн хөтөлбөрөөр төгсөж гарсан оюутан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэх, өрсөлдөх, хөрвөх чадамжтай бүтээгдэхүүн, боловсон хүчин болж төгсөнө.

- 2) Суралцахуйн үр дүнгийн уялдаа хамаарлыг тооцоогүйтэй холбоотой гарч байгаа өөр нэг дутагдалтай тал нь үнэлгээ хийгдсэн хичээлийн хөтөлбөрийн сургалтын арга зүй нь адил төстэй байдал юм. Сургалтад ашиглагдаж байгаа сургалтын арга зүй нь уламжлалт, бие биенээ дуурайсан мэт ижил төстэй, сургалтын шинэлэг арга хэлбэрүүдийг төлөвлөөгүй байсан. Иймд цаашид багш нарын заах арга зүй хандлагыг илүү сайжруулах, сургалтын арга барилын шинэлэг арга аргачлалын талаар сургалтууд зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдсан.
 - 3) Мөн сургалтын үнэлгээний аргачлал бүгд ижил, ихэвчлэн мэдлэг үнэлэх арга хэрэгслүүд байгаа нь мөн адил үнэлгээний аргачлалыг суралцахуйн үр дүнтэй уялдаагүйтэй холбоотой. Үнэлгээний зөвхөн мэдлэг үнэлэх арга хэлбэрүүдийг бичсэн нь ур чадвар, хандлагыг хэрхэн үнэлэх талаар багш нарын хандлага, практик ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
 - 4) Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сэдэв тус бүрээр нарийвчлан тодорхойлоогүй, зарим хөтөлбөрт маш товч дурьдагдах төдий өнгөрсөн байна гэсэн дүгнэлтээс үзэхэд, багш нарын хичээлийн төлөвлөлтийг ялангуяа бүлэг сэдэв, нэгж хичээлийн сэдэв тус бүрээр нарийвчилсан төлөвлөх, хэрэглэгдэхүүнийг сургалтын арга зүйтэй уялдуулан тооцдог болгох, сургалтын технологийн талаар дэлгэрэнгүй сургалт зохион байгуулах, сургалтын үр дүнг үнэлэх, хичээлийн явцад хяналт үнэлгээ хийх дараа дараагийн ажлууд төлөвлөн ажиллах хэрэгтэйг харуулж байна.
- 4. Хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад тулгарч болох эрсдэл, бэрхшээл (Threads)**

Хичээлийн хөтөлбөр боловсруулалтыг сайжруулахад тулгарч болох нэг эрсдэл нь CDIO стандарт, арга зүй “Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж,” ”Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүд тодорхойлох арга зүйн зөвлөмж,”-ийн багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх байж болно. Үүнд гол анхаарах зүйл нь суралцахуйн үр дүн буюу тухайн хичээлээр олж авах цогц чадамжийг хичээлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн тус бүртэй уялдуулан тооцох ур чадварыг багш нарт эзэмшүүлэх нь эхний том сорилт болох юм. Хэдийгээр АШУҮИС-аас боловсруулсан “Мэргэжилтний цогц чадамж” гарын авлагын дагуу зарим мэргэжлийн цогц чадамжийг тодорхойлон хөтөлбөрт тусган ажиллаж байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд илүү нийцүүлэхийн тулд ажил олгогч нартай илүү ойр дотно ажиллах шаардлага гарч ирж байгаа.

Мөн орчин үеийн стандарт хангасан сургалтын орчинг бий болгох техник төхөөрөмж, програм хангамж, сургалтын орчинг бий болгох, багшийн хандлага заах арга зүйг илүү оюутан төвтэй, оюутны бие даан суралцах, мэдлэг бүтээх, хэрэглэх тал дээр илүү анхааран сайжруулах, сургалтын үнэлгээний аргачлалыг оюутан хэрхэн бие даан суралцан, мэдлэг чадвар бүтээж байгаа байдлыг үнэлэх шинэлэг арга хэлбэрүүдийг түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Энэ бүхнийг багш нарыг төрөл бүрийн сургалтад хамруулах, багийн ажиллагаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, сэдэлжүүлэх, нээлттэй хичээлүүд зохион байгуулах, судалгаа эрдэм шинжилгээний ажилтай холбох зэрэг төрөл бүрийн арга хэмжээгээр шийдвэрлэж болох юм.

Боловсруулсан:

ЧБХҮА-ны дарга Э.Бямбасүрэн

Танилцсан:

Гүйцэтгэх захирал Д.Найгалмаа